



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Гал унтраах тактикийн дадлага, сургууль
зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.7, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.2.4, 51 дүгээр зүйлийн 51.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалт, Архивын ерөнхий газрын 2021 оны “Гал унтраах тактикийн дадлага сургууль” хийх төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг буруулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлага олгох, галын бүлгэмийн гүйцэтгэх үүргийг тодотгох, гал түймэр гарсан тохиолдолд хохирол багатай унтраах арга зүйг таниулах, онцгой байдлын байгууллагын мэргэжлийн ангиудтай харилцан хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гал унтраах танхимын болон тактикийн сургуулийг 12 дугаар сарын 9,10-ны өдрүүдэд зохион явуулсугай.

2. Сургууль зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, шаардагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургууль зохион байгуулах зардал 650,000 (зургаан зуун тавин мянга) төгрөгийг төсвийн холбогдох зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Х.Цогтбаатар/-т зөвшөөрсүгэй.


4. Гал унтраах тактикийн дадлага, сургуульд Архивын ерөнхий газрын ажилтан албан хаагч нарыг идэвхтэй оролцуулахыг Гал түймрийн улсын хяналтын байцаагч /Г.Жаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭНХБААТАР

Архивын ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 06-ны
өдрийн 11 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЛ УНТРААХ ТАКТИКИЙН ДАДЛАГА,
СУРГУУЛЬ ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2021.12.01

Улаанбаатар хот

Нэг: Дадлага, сургуулийн зорилго

Гамшгаас хамгаалах тухай хууль болон Галын аюулгүй байдлын тухай хуульд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар Архивын ерөнхий газрын ажилтан, албан хаагчдад сургалт дадлага зохион байгуулж гарч болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг унтраах арга ажиллагаанд сургаж дадлагажуулахад чиглэгдэнэ.

Хоёр: Дадлага, сургууль явуулах хугацаа, бүрэлдэхүүн

Сургуулийг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд 09:00 цагт Архивын ерөнхий газрын 4 давхрын хурлын танхимд цахим, танхим хосолсон явагдана.

Сургуулийг Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Г.Жаргал хариуцан зохион байгуулна.

Гурав: Дадлага сургуулийн чиглэл

Сургуулиар: Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголоор албан хаагч нар өөрсдийн гүйцэтгэх үүргийн ойлголт, гал түймрийн аюулаас хамгаалах урьдчилан сэргийлэх арга ажиллагаа, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах талаар анхан шатны ойлголт болно.

Дөрөв: Тактикийн сургуулиар хийгдэх ажиллагаа

2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 10:00 цагт Архивын ерөнхий газрын 5 дугаар давхрын цайны газрын өрөөнд галын дохиолол ажилласнаар харуул хамгаалалтын албаны ажилтан галын дохиоллын удирдлагын төв өрөөнд орж галын дохиоллын самбарыг харж хэдэн давхарт, хэдэн тоотод гал гарч байгааг олж тогтоон гал унтраах анхан шатны арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Дээд давхруудад хорт хий утаа ихээр тархсан, өрөө бүрийн бүртгэл судалгааг гаргахад 5 дугаар давхрын цайны газарт галын голомт байгааг олж тогтоон МШУ Төвийн тусгай албаны 101 утсанд дуудлага өгснөөр гал унтраах ажиллагаа эхэлнэ.

Гал унтраах анги ирэхээс өмнө Архивын ерөнхий газрын штабын дарга нь гамшгаас хамгаалах бүлгийн бүрэлдэхүүнийг удирдан зохион байгуулж шуурхай албаны автомашин хүрэлцэн очих боломжийг бүрдүүлж замын зохицуулалт, гал гарсан өрөө тасалгаанд байгаа тоног төхөөрөмж, архивын бичиг баримтыг нүүлгэн шилжүүлж хүмүүсийг аврах, гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмжийг ашиглах, бэртэж гэмтсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үйл ажиллагааг бодит

бэртэж гэмтсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үйл ажиллагааг бодит дадлагаар хийж гал унтраах анги ирмэгц байгууллагын удирдах албан тушаалтан тосон авч мэдээллээр хангаж ажиллана.

Цагийн байдал:1 Гал түймэр унтраах үйл ажиллагаа

Анхны дуудлагаар Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 30 дугаар ангийн 1 тасгийг хүрэлцэн ирэх хугацаанд тухайн объектын захиргаа, галын бүлгэмийн гишүүд өөрсдийн үүргийг гүйцэтгэнэ. Гал түймэр унтраах, аврах ангийн бүрэлдэхүүнийг ирэхэд хүлээн авч гал түймэр гарсан нөхцөл байдал, объектын онцлог, авралтын зам гарц, усан хангамжийн талаар товч танилцуулна.

Анхны дуудлагаар хүрэлцэн ирсэн Гал унтраах удирдагч гал түймрийн нөхцөл байдалд үнэлгээ өгсний үндсэн дээр нэмэлт хүн, хүч хэрэгслийг дуудан галын хайгуулын хэсгийг унтраах үйл ажиллагаатай хослуулан зохион байгуулна.

Гал түймэр унтраах аврах 30-р ангийн тасгийн бүрэлдэхүүн объектын баруун урд талд 10 метрийн зайд галын автомашиныг байрлуулж төв шугам 40 метр ажлын шугам тус бүр 40 метр салаа бэлчиртэй, РСА, ГПС-600 хушуутай тархан барилгын баруун талын авралтын хаалгаар 1 дүгээр давхарт гарч гал гарсан өрөөнд хамгийн богино дөт замыг сонгон гал түймрийг унтраах үйл ажиллагаа явуулж, хайгуулын ажиллагааг гал түймрийн дуудлагаар очсоноос эхлээд унтрааж дуустал тасралтгүй хийнэ.

Нэмэлт дуудлагаар Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн тасгийн бүрэлдэхүүн барилгын зүүн урд талд галын автомашиныг байрлуулж, төв шугам 40 метр ажлын шугам тус бүр 40 метр салаа бэлчиртэй ГПС-600 хушуутай барилгын урд талын хаалгаар 1 давхарт гал гарсан өрөөнд хамгийн дөт замыг сонгон нь унтраах ажиллагааг зохион байгуулна. Гал унтраах удирдагч угтан авч, гал унтраах шуурхай штабыг байгуулж шаардлагатай хүн, хүч хэрэгслийн тооцоог гарган, ажиллах байрлал, дараалал, гүйцэтгэх чиг үүргийг өгч гал унтраах байлдааны, хорт хий утааны, галын хайгуулын, арын алба, холбоо зохион байгуулах хэсгүүдийг томилж авралтын үйл ажиллагааг гал унтраах үйл ажиллагаатай нэгэн зэрэг явуулж хүний амь бие, байгууллагын эд хөрөнгийг авран хамгаалах, гарсан гал түймрийг богино хугацаанд хохирол багатай унтраах үйл ажиллагааг зохион байгуулна.

Цагийн байдал:2 Аврах үйл ажиллагаа

Гал түймэр унтраах, аврах 30 дугаар ангийн автомеханик шатыг Архивын ерөнхий газрын урд талбайд байрлуулан барилгын дээвэр дээр утаанд боогдсон буух боломжгүй 2-4 албан хаагчийг аврах үйл ажиллагааг зохион байгуулж автомеханик шатыг дээврийн хэсэгт байрлуулан албан хаагч нарыг аюулгүй зай талбайд буулгаж анхны тусламж үзүүлэх.

Нийслэлийн аврах анги 105-ын бүлгийн аврагчид барилгын 2-5 дугаар давхарт утаанд боогдсон, бэртсэн байгууллагын албан хаагч нарыг хорт хий утаанаас хамгаалах багны тусламжтай барилгын дээвэр дээрээс болон дотор шатаар буулгах, 2-5 нэрвэгсдэд эмнэлгийн анхан шатны үзлэг тусламж үзүүлэн аврах ажиллагааг явуулна.

Цагийн байдал: 3 Дадлага сургууль явуулах үйл ажиллагаа


Тухайн объектын ажилчид, албан хаагч нарт галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийж, тусгайлан бэлдсэн талбай дээр тухайн байгууллагын галын бүлгэмийн гишүүдээр MFZ-4 маркийн хуурай /нунтаг/ гал унтраагуулаар гал унтраах үзүүлэх сургалт явуулж дадлага сургууль олгоно.

11:00 цагт нийслэлийн Онцгой байдлын газар, Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн удирдлага нар тактикийн сургуулийн ололт, амжилт, алдаа дутагдал, цаашид анхаар зүйлсийг нэгтгэн дүгнэж, тактикийн сургуульд оролцсон алба хаагчдад, Архивын ерөнхий газрын ажилтнуудад дүнг танилцуулснаар дуусгана.

Д/д	Хичээлийн сэдэв	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах талаар анхан шатны талаар ойлголт	30 минут	Ахлах дэслэгч Л. Баттогтох
2.	Гал унтраах тактикийн сургуулийн төлөвлөгөө, удирдамж, сургууль явагдах дараалал талаар ойлголт	30 минут	Ахмад Г.Жаргал

---oOo---

Архивын ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 06 -ны
өдрийн 1/100 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



СУРГУУЛЬД ХЭРЭГЛЭГДЭХ БАГАЖ ЗЭВСЭГЛЭМЖ, ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Багаж хэрэгслийн нэрс	Хэмжээ	Хариуцах байгууллага
1	Гал асаах тэвш	1 ширхэг	Гал түймэр унтраах аврах анги
2	Гал унтраагуур	10 ширхэг	Архивын ерөнхий газар
3	Утаа гаргагч шашка	2 ширхэг	Архивын ерөнхий газар
4	Түлш /Дизель/	10 литр	Архивын ерөнхий газар
5	Бензин	5 литр	Архивын ерөнхий газар
6	Штабын ширээ сандал	2 ширхэг	Архивын ерөнхий газар
7	Чанга яригч	1 ширхэг	Архивын ерөнхий газар

№	Шатахуун	Гал түймэр унтраах ангийн автомашинд 250000
1	Хөөс үүсгэгч	20 л x 11,000=220,000
2	Утаа/ шашиг/	2 ширхэг -90,000
3	Хулдаасан хэвлэл	50,000
4	Бичиг хэрэг	10,000
5	Тэвшиндэх гал асаах /бензин, түлш /	30,000
6	Нийт	650,000

---oOo---